

**ГОВИЙН БҮСЭД НАВЧИТ МОДНЫ БОРТОГОТОЙ СУУЛГАЦ,
 ЗАГИЙН БОРТОГОТОЙ СУУЛГАЦААР ОЙЖУУЛАЛТ ХИЙХ
 АЖЛЫН ДААЛГАВАР /ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/**

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан “Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө”-д тусгагдсан говь, хээрийн бүсийг ойжуулах, нөхөн сэргээх говийн бүсэд навчит модны бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хамрах хүрээ	Навчит модны бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Ойжуулалт хийх талбайн байршлыг ажлын даалгаварт хавсаргав.
3	Гүйцэтгэх ажил	Навчит модны бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулалт хийх, нэг жилийн хугацаанд арчлах, нөхөн тарилт хийх
	Төсөвт өртөг	1,412,000,000.00 /нэг тэрбум дөрвөн зуун арван хоёр сая/ төгрөг
4	Талбайн хэмжээ	80 га талбай
5	Техникийн шаардлага	Говийн бүсийг навчит модны бортоготой суулгац, загийн бортоготой суулгацаар ойжуулах, арчлах ажлыг гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгац, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг мөрдөж ажиллана.
6	Модны төрөл	Заг, Сухай, Хайлаас
7	Хугацаа	Хаврын тарилт 2024.05.05 Намрын нөхөн тарилт 2024.10.01 Дараах жилийн арчилгаа, нөхөн тарилт 2025.05.05 Тендерийн баримт бичигт заагдсан үе шатны ажлын хуваарь болон, гүйцэтгэгчээс ирүүлсэн тодотгосон үе шатны ажлын хуваарьтай уялдан өөрчлөгдөж болно.
8	Ажлын үе шат	Навчит модны бортоготой суулгацаар ойжуулах ажил нь дараах ажилбаруудаас бүрдэнэ. <ul style="list-style-type: none"> - Бэлтгэл ажил - Ойжуулалт хийх - Ойжуулсан талбайг хамгаалах хашаа барих - Усалгааны систем, нөөцийн сав байрлуулах - Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх - Зөрчил гологдол арилгах - Тайлан боловсруулах - Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх - Дараа жилийн арчилгаа хамгаалалт

10	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p>Бэлтгэл ажил</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах; • Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох; • Ойжуулалтын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дарааллын загварыг хавсаргав/ • Ойжуулах талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцөн сонгох/; • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Бортоготой суулгацыг мод үржүүлгийн талбайгаас тээвэрлэхэд бэлдэх; • Суулгацыг хатахаас хамгаалах, сүүдэрт хадгалах, хадгалах хугацаанд байнга услах, сэрүүн үед битүү машинаар тээвэрлэх; • Усалгааны систем, нөөцийн сав суурилуулах • Мал бэлчээрлэлтийн нөлөө их тул ойжуулалтын талбайг бүхэлд нь хашиж хамгаална. • Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах
11		<p>Ойжуулалт хийх</p> <ul style="list-style-type: none"> • “Мод сөөгийн тарьц. Техникийн шаардлага” навчит төрлийн модны тарьц, суулгац нь MNS 6141:2010 стандартын шаардлага хангасан байх шаардлагатай. • Ойжуулалтын ажилд 1 га талбайд стандартын загийн бортоготой суулгац 1250 ш, бусад төрлийн навчит модны суулгац 250 ш доошгүй байна. • Шилжүүлэн суулгах загийн бортоготой суулгац газрын дээд хэсгийн өндөр 15-17 см-ээс багагүй, үндэсний урт 17-20 см-ээс богиногүй байх. • Ойжуулалт хийх тарилтын нүхийг шан татаж бэлтгэх бөгөөд эгнээ хооронд 4 м зайтай газрын гадаргаас 30 см гүн шуудуу татах • Загийн бортоготой суулгацаар ойжуулалт хийхэд татсан шуудуунд мод хооронд 1.5 зайтай тарих • Нүхэнд 20-25 см диаметртэй 25-30 см орчим гүн нүх бэлтгэх ба модны нүх ухагч моторт багаж болон трактороор нүхийг ухаж бэлтгэнэ. • Ойжуулалтын шигүүрэл: Мод хоорондоо 1.5 метр, эгнээ хооронд 4 метр байхаар тооцон 1 га талбайд 1650 ширхэг тарьц байхаар тооцож тарилт хийх /Схем 1/ • Ухаж бэлтгэсэн нүхийг услах • Усалсны дараа бортоготой суулгацын ёроолыг бүрэн хагалж задгайлж суулгаж, чигжих

		<ul style="list-style-type: none"> • Тарилтын дараа дахин услах • Нэг жилийн арчилгаа хамгаалалтын хугацаанд хөрсний чийг тохиромжтой хувиас доогуур тохиолдолд усалгаа, арчилгааг хийх • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх ажилчдын 50 хүртэл хувь нь ойролцоо нутгийн малчдаас бүрдүүлнэ. • Мэдээллийн самбар байрлуулна. Самбарын нийт өндөр 3 метрээс багагүй, төмөр хийцтэй байх бөгөөд самбарын хэмжээ 1x1 метрээс багагүй байна Самбарын хөлийн бетон зуурмагаар бэхэлсэн байна. Самбарын мэдээлэлд ойжуулалт хийсэн талбайн зураг, захиалагч болон гүйцэтгэгчийн тухай мэдээлэл, талбайн хэмжээ, тарьсан модны төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллүүдийг заавал оруулсан байна. • Ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэж буй аж ахуйн нэгж нь ажлын явцын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт ирүүлэх. 															
12		<p>Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулсан талбайг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Ойжуулалтын ажлын явцын хяналтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэг, Ойн газартай гэрээ байгуулсан хөндлөнгийн хяналтын баг тус тус хийж гүйцэтгэнэ. Ойжуулсан талбайг тухай аймаг, суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц, суулгацын амьдралд 75.0 хувиас дээш байвал уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна. Амьдралын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна. <table border="1" data-bbox="667 1576 1465 1899"> <thead> <tr> <th>Ойжуулсан талбай /га/</th> <th>Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь</th> <th>Нэгж жишигталбайн хэмжээ /м²/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1-5</td> <td>5</td> <td>200</td> </tr> <tr> <td>6-10</td> <td>4</td> <td>400</td> </tr> <tr> <td>11-20</td> <td>3</td> <td>400</td> </tr> <tr> <td>21-ээс дээш</td> <td>2</td> <td>400</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойнаж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг 	Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишигталбайн хэмжээ /м ² /	1-5	5	200	6-10	4	400	11-20	3	400	21-ээс дээш	2	400
Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишигталбайн хэмжээ /м ² /															
1-5	5	200															
6-10	4	400															
11-20	3	400															
21-ээс дээш	2	400															

		<p>үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна /Маягтыг хавсаргав/. Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана.</p>
13		<p>Зөрчил, гологдол арилгах</p> <ul style="list-style-type: none"> • Тарьсан тарьц нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө. • Тарьсан тарьц нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. • Тарьсан тарьц нь 24,9 хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.
14		<p>Тайлан боловсруулах.</p> <ul style="list-style-type: none"> • Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: <p>а/ “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>б/ 1:50000-ны масштабтай Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг;</p> <p>в/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.</p> <p>а. “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”-д: Ойжуулалтын ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ойжуулалтын ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойжуулсан талбайн ерөнхий байдлын зургийг тайланд хавсаргана.</p> <p>б. “Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.</p> <p>в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана. Тайланг захиалагчийн</p>

		<p>даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.</p> <p>Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28- ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтын тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.</p> <p>Ойжуулалтын ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.</p>
15		<p>Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <p>Ойжуулалтын ажлын тайланг Ойн газарт гурван хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгана. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</p>
16		<p>Дараа жилийн арчилгаа, хамгаалалт</p> <p>“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу ойжуулсан талбайгаа 1 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно. Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, усалгаа хийх, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээг гэрээ хүчинтэй хугацааны турш хийж гүйцэтгэнэ.</p>
17	Бусад тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> • Ажлын гүйцэтгэхэд шаардлагатай нийт ажилчдын 50 хүртэл хувийг тухайн сум орон нутгийн иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хамтран гүйцэтгэх, тухайн орон нутгийн мод үржүүлгийн газраас тарьц, суулгац худалдан авах. • Ойжуулалтын талбайд гарсан хог хаягдлыг цэвэрлэж, хогийн төвлөрсөн цэг рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулна. • Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын үе шат бүрийг захиалагчид фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. Үүний дараа дараагийн үе шатны ажлыг эхэлнэ.

Үе шатны ажлын хуваарь

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	2024-06-20-ны дотор
2	Ойжуулалт хийх	2024-09-10-ны дотор
3	Талбайг хүлээлгэн өгөх	2024-09-20-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	2024-10-01-ний дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	2024-11-01-ны дотор
6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	2024-11-10-ны дотор
7	Арчилгаа, хамгаалалт	2025-12-01-ны дотор

Ажил гүйцэтгэх байршил /багцын мэдээлэл/

№	Багцын дугаар	Багцын нэр	Талбайн хэмжээ, га	1 га талбайд таригдах модны модны тоо	1 га талбайн зардлын норматив, төгрөгөөр	Нийт таригдах модны тоо	Төсөвт өртөг, төг	Талбайн байршил, координат	Талбайн байршил, ОЗБ-ын материал
1	Багц 2	Говь-Алтай аймгийн Цээл сумын Сүүж баг	10	1500	17,650,000.00	15,000.00	176,500,000.00		
2	Багц 7	Өмнөговь аймгийн Булган сум	15	1500	17,650,000.00	22,500.00	264,750,000.00		
ДҮН			25	3000	17,650,000.00	37,000.00	1,412,000,000.00		

Хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга

Б.Ганзориг

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Өсөхбаяр

Боловсруулсан:

Говь, хээрийн бүсийн ойжуулалт цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Н.Барсболд